ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Дорнод аймгийн Халхгол сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2023/135/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2023 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Нармандах<br>Утас: 7058-4207, Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn<br>Аудитор Ц.Төмөрсүх<br>Утас: 9805-8805, Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга..........................................................................................
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
   4.1 Ерөнхий зүйл ..........................................................................................................................
   4.2 Материаллаг байдал ...............................................................................................................
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт..................................................................................
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................................
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ...............................................................
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ...........................................................................
5. Аудитын илрүүлэлт .......................................................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 261

танай ______-ны № ______-т

ХАЛХГОЛ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Д.ДАШ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халхгол сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халхгол сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020362

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **235,434,802.89** | **198,269,842.02** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 71,790,247.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 71,790,247.00 |
| **3121** | **Төгрөг** | - | 71,790,247.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 71,790,247.00 |
| **33** | **АВЛАГА** | 144,020,281.00 | 3,776,621.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 875,300.00 | - |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 137,232,460.00 | - |
| **335** | **Бусад авлага** | 5,912,521.00 | 3,776,621.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,407,421.00 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 4,505,100.00 | 3,776,621.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 91,414,521.89 | 122,702,974.02 |
| **351** | **Түүхий эд материал** | 42,146,011.83 | 47,204,448.96 |
| 35130 | Эм боох материал | 42,146,011.83 | 47,204,448.96 |
| **354** | **Хангамжийн материал** | 49,268,510.06 | 75,498,525.06 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,825,400.00 | 4,102,600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 37,888,740.06 | 66,254,690.06 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 6,530,000.00 | - |
| 35450 | Барилгын засварын материал | 568,920.00 | - |
| 35460 | Хүнсний материал | 2,347,330.00 | 5,141,235.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 108,120.00 | - |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,063,190,995.64** | **3,090,255,465.85** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,063,190,995.64 | 3,090,255,465.85 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,033,872,995.72 | 3,061,062,465.97 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,841,809,552.94 | 2,841,809,552.94 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (125,952,538.20) | (183,809,320.32) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 96,271,434.00 | 134,171,434.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (60,184,133.88) | (84,818,122.79) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 324,990,179.09 | 431,880,785.39 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (91,819,178.88) | (135,105,043.95) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 49,135,593.45 | 63,745,685.74 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (7,471,603.82) | (12,985,065.30) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 15,354,622.00 | 15,354,622.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (8,260,930.98) | (9,182,061.74) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 29,317,999.92 | 29,192,999.88 |
| 39301 | Програм хангамж | 500,000.00 | 500,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (250,000.08) | (375,000.12) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 29,068,000.00 | 29,068,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,298,625,798.53** | **3,288,525,307.87** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,353,790.00** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,353,790.00 | - |
| **413** | **Өглөг** | 1,353,790.00 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,353,790.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,297,272,008.53** | **3,288,525,307.87** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,297,272,008.53 | 3,288,525,307.87 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 397,725,417.26 | 397,725,417.26 |
| 51101 | Өмч: - төрийн | 397,725,417.26 | 397,725,417.26 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,696,551,809.17 | 2,687,805,108.51 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,696,551,809.17 | 2,696,551,809.17 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (8,746,700.66) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 202,994,782.10 | 202,994,782.10 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,298,625,798.53** | **3,288,525,307.87** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,792,290,014.96** | **974,028,981.65** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **639,692,734.96** | **136,562,791.65** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 101,895,694.96 | 136,562,791.65 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 101,895,694.96 | 136,562,791.65 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,678,500.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 24,112,174.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө | 39,442,449.54 | 113,181,442.65 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал | 31,662,571.42 | 23,381,349.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 6,889,840.00 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 6,889,840.00 | - |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 530,907,200.00 | - |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 530,907,200.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,152,597,280.00** | **837,466,190.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 641,338,000.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 641,338,000.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 438,074,500.00 | 6,585,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,097,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 295,867,540.00 | 6,550,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 35,000.00 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 137,109,960.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 45,106,400.00 | 49,119,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 45,106,400.00 | 49,119,200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 28,078,380.00 | 781,761,990.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 28,078,380.00 | 781,761,990.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,128,087,399.73** | **982,775,682.31** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,128,087,399.73** | **982,775,682.31** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,087,121,401.73 | 982,575,682.31 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 501,402,407.00 | 457,134,134.00 |
| 210101 | Үндсэн цалин | 371,279,107.00 | 278,326,005.00 |
| 210102 | Нэмэгдэл | 84,038,800.00 | 137,500,477.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,065,400.00 | 5,251,000.00 |
| 210104 | Урамшуулал | 38,019,100.00 | 36,056,652.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 68,135,834.00 | 50,718,622.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,314,334.00 | 34,791,952.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,705,400.00 | 4,106,571.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,964,300.00 | 3,144,263.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 741,000.00 | 777,313.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,410,800.00 | 7,898,523.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 43,140,402.00 | 44,119,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,334,002.00 | 5,739,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 34,206,400.00 | 34,778,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,600,000.00 | 3,601,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 42,976,738.46 | 67,570,116.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,489,821.00 | 4,180,040.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 24,958,440.00 | 43,431,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,032,500.00 | 1,718,395.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,150,000.00 | 4,200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,345,227.46 | 14,040,681.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 750.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 195,046,695.73 | 191,330,987.87 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 156,854,025.73 | 154,235,052.87 |
| 210502 | Хоол, хүнс | 34,720,770.00 | 35,434,135.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,471,900.00 | 1,661,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,098,700.00 | 11,914,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,016,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 2,082,700.00 | 11,914,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,660,000.00 | 7,114,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,660,000.00 | 7,114,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 525,200.00 | 3,733,890.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 985,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 270,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 177,800.00 | 177,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 181,200.00 | 181,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,972,690.00 |
| 210807 | Газрын төлбөр | 40,200.00 | 40,200.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 27,000.00 | 107,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 229,135,424.54 | 148,940,332.44 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,551,917.00 | 18,063,860.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 221,583,507.54 | 130,876,472.44 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 40,965,998.00 | 200,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 40,600,000.00 | 200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 40,600,000.00 | 200,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 365,998.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 365,998.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **664,202,615.23** | **(8,746,700.66)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 310,936,595.94 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 310,936,595.94 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (310,936,595.94) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **353,266,019.29** | **(8,746,700.66)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,559,962,860.00** | **974,698,650.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **544,475,540.00** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 6,678,500.00 | - |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 6,678,500.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,678,500.00 | - |
| **122** | **Тусламжийн орлого** | 6,889,840.00 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 6,889,840.00 | - |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 530,907,200.00 | - |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 530,907,200.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,015,487,320.00** | **974,698,650.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 641,338,000.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 641,338,000.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 300,964,540.00 | 143,817,460.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,097,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 295,867,540.00 | 6,550,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 35,000.00 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | | 137,232,460.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 45,106,400.00 | 49,119,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 45,106,400.00 | 49,119,200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 28,078,380.00 | 781,761,990.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 28,078,380.00 | 781,761,990.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,022,165,820.00** | **902,908,403.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,022,165,820.00** | **902,908,403.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **981,199,822.00** | **902,708,403.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 499,447,520.00 | 456,405,655.00 |
| 210101 | Үндсэн цалин | 369,324,220.00 | 277,597,526.00 |
| 210102 | Нэмэгдэл | 84,038,800.00 | 137,500,477.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,065,400.00 | 5,251,000.00 |
| 210104 | Урамшуулал | 38,019,100.00 | 36,056,652.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 68,135,834.00 | 50,718,622.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,314,334.00 | 34,791,952.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,705,400.00 | 4,106,571.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,964,300.00 | 3,144,263.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 741,000.00 | 777,313.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,410,800.00 | 7,898,523.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 43,140,402.00 | 44,119,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,334,002.00 | 5,739,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 34,206,400.00 | 34,778,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,600,000.00 | 3,601,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 46,729,180.00 | 60,191,435.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,675,300.00 | 6,554,240.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 28,699,380.00 | 36,901,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,032,500.00 | 1,746,195.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,150,000.00 | 4,200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,172,000.00 | 10,790,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 188,464,686.00 | 187,466,341.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 146,836,986.00 | 134,408,851.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,693,100.00 | 39,178,290.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,934,600.00 | 13,879,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 114,097,000.00 | 50,585,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 107,400,000.00 | 30,000,000.00 |
| 210602 | Тавилга | - | 1,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,697,000.00 | 18,985,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,660,000.00 | 7,114,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,660,000.00 | 7,114,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 525,200.00 | 6,748,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 4,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 270,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 177,800.00 | 177,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 181,200.00 | 181,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,972,200.00 |
| 210807 | Газрын төлбөр | 40,200.00 | 40,200.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 27,000.00 | 107,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 18,000,000.00 | 39,359,750.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,000,000.00 | 39,359,750.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **40,965,998.00** | **200,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 40,600,000.00 | 200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 40,600,000.00 | 200,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 365,998.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 365,998.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **537,797,040.00** | **71,790,247.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 537,797,040.00 | 71,790,247.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 71,790,247.00 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 397,725,417.26 | 202,994,782.10 | 2,905,194,253.88 | 3,505,914,453.24 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **397,725,417.26** | **202,994,782.10** | **2,905,194,253.88** | **3,505,914,453.24** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 353,266,019.29 | 353,266,019.29 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **397,725,417.26** | **202,994,782.10** | **2,696,551,809.17** | **3,297,272,008.53** |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **397,725,417.26** | **202,994,782.10** | **2,696,551,809.17** | **3,297,272,008.53** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **397,725,417.26** | **202,994,782.10** | **2,696,551,809.17** | **3,297,272,008.53** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (8,746,700.66) | (8,746,700.66) |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **397,725,417.26** | **202,994,782.10** | **2,687,805,108.51** | **3,288,525,307.87** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон | | | /Төгрөгөөр/ |
|---|---|---|---|
| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,016,064,900.00 | 902,908,403.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,016,064,900.00 | 902,908,403.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,015,864,900.00 | 902,708,403.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 527,328,600.00 | 456,405,655.00 |
| 210101 | Үндсэн цалин | 308,496,200.00 | 277,597,526.00 |
| 210102 | Нэмэгдэл | 144,381,000.00 | 137,500,477.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,951,400.00 | 5,251,000.00 |
| 210104 | Урамшуулал | 64,500,000.00 | 36,056,652.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 65,916,100.00 | 50,718,622.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,822,900.00 | 34,791,952.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,273,400.00 | 4,106,571.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,218,600.00 | 3,144,263.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,054,700.00 | 777,313.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,546,500.00 | 7,898,523.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 44,119,200.00 | 44,119,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,739,000.00 | 5,739,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 34,778,400.00 | 34,778,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,601,800.00 | 3,601,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 60,449,800.00 | 60,191,435.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,814,000.00 | 6,554,240.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 36,901,000.00 | 36,901,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,744,800.00 | 1,746,195.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,200,000.00 | 4,200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,790,000.00 | 10,790,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 196,877,900.00 | 187,466,341.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 134,442,300.00 | 134,408,851.00 |
| 210502 | Хоол, хүнс | 48,556,400.00 | 39,178,290.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 13,879,200.00 | 13,879,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 50,600,000.00 | 50,585,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 30,000,000.00 | 30,000,000.00 |
| 210602 | Тавилга | 1,600,000.00 | 1,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 19,000,000.00 | 18,985,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,504,000.00 | 7,114,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,504,000.00 | 7,114,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,008,200.00 | 6,748,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | 270,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 177,800.00 | 177,800.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 181,200.00 | 181,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,000,000.00 | 1,972,200.00 |
| 210807 | Газрын төлбөр | 40,200.00 | 40,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 150,000.00 | 107,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 54,061,100.00 | 39,359,750.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 54,061,100.00 | 39,359,750.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 200,000.00 | 200,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 200,000.00 | 200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 200,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,016,064,900.00 | 974,698,650.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 49,119,200.00 | 49,119,200.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 49,119,200.00 | 49,119,200.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 966,945,700.00 | 925,579,450.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 966,945,700.00 | 925,579,450.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **71,790,247.00** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорнод аймгийн Халхгол сумын Эрүүл мэндийн төв нь эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг ард иргэдэд жигд хүртээмжтэй хүргэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүн амын амьдралын хэв маягийг өөрчлөх, зөв дадал зуршилд сургахад чиглэгдэнэ.

Эрхэм зорилго: Иргэдэд нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг шуурхай ил тод, тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлэх замаар амьдралын чанарыг сайжруулах, дундаж наслалтыг уртасгахад оршино.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ард иргэдэд хүргэн үйлчилж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн Халхгол сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дорнод аймгийн Халхгол сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10.1 сая төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 71,790.2 | 71,790.2 |
| Авлага | 144,020.3 | 3,776.6 | (140,243.7) |
| Бараа материал | 91,414.5 | 122,703.0 | 31,288.5 |
| Үндсэн хөрөнгө | 3,063,191.0 | 3,090,255.5 | 27,064.5 |
| **Нийт хөрөнгө** | **3,298,625.8** | **3,288,525.3** | **(10,100.5)** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,353.8 | - | (1,353.8) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 3,297,272.0 | 3,288,525.3 | (8,746.7) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **3,298,625.8** | **3,288,525.3** | **(10,100.5)** |

Дээрх хүснэгтээс харахад авлага өмнөх оноос 140.2 сая төгрөгөөр буюу Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 137.2 сая төгрөгийн төлбөрт үйлчилгээний авлага, хувь хүнээс авах авлага 3.0 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Бараа материал данс 31.2 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс 27.0 сая төгрөгөөр өссөн нь 164.7 саяын хөрөнгө орлогод бүртгэж, 5.1 саяын хөрөнгө данснаас хасаж, тайлант онд 130.0 сая төгрөгийн элэгдэл тооцож бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 3,288.5 сая төгрөг болж 8.7 сая төгрөгөөр буурсан нь тайланд хугацааны алдагдалтай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,016.0 сая, нийт зарлагыг 1,016.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны

төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаар 1,016.0 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 974.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 902.9 сая төгрөг буюу 88.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 71.8 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсөвтэй холбоотой ажил гүйлгээ гараагүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн Халхгол сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Нурболат, аудитор Ц.Төмөрсүх, хяналтыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудит менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Халхгол сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 2 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 982.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 14.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор санхүүгийн сахилга батыг мөрдөж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлан ажилласан байна.

Тухайн байгууллагын батлагдсан орон тоон дээр дэд дарга, орлогчийн албан тушаалын ажилтан байхгүй байгаа бөгөөд авто тээврийн хэрэгсэл нь эмнэлгийн тусламж үйлчилгээ буюу төрийн хэмнэлтийн хуулийн 6 дугаар зүйлд заасан авто тээврийн хэрэгсэл ашиглах хэрэгцээ, шаардлагатай байгууллага байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд 3 байгууллагаас 14.3 сая төгрөгийн худалдан авалтад цахим төлбөрийн баримт гаргуулан аваагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, сангийн сайдын 2017 оны 347 тушаалаар батлагдсан өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавbooрын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм…” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүллээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 2 албан шаардлага, 1 төлбөрийн акт хүргүүлсэн бөгөөд хэрэгжилт 100 хувь биелэлтэй байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| **Үзүүлэлт** | **Өмнөх аудитын үзүүлэлт** | | **Биелэлт** | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| | | | | | |
| Албан шаардлага | 2 | 78,620,0 | 2 | 78,620,0 | 100 |
| Төлбөрийн акт | 1 | 1,353.7 | 1 | 1,353.7 | 100 |
| **Нийт дүн** | **1** | **79,973.7** | **1** | **79,973.7** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдах авах гэрээ, тайланг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуультай нийцэж байх эсэхийг үзэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24.2 сая төгрөгийн зөрчил[1] илэрснийг 1 зөвлөмж, 2 албан шаардлага хүргүүлсэн болно.

### 5.1 Албан шаардлага

1. Оны эцсийн дансны авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### 5.2 Зөвлөмж

1. ***Илрүүлэлт:*** Б/33 тушаал /илүү цаг 26 ажилтан тус дунджаар 35 цаг/, ажлын цаг ашиглалтын бүртгэл хөтлөлт хангалтгүй байна. Энэ нь сангийн сайдын 2017 оны 347 тушаалаар батлагдсан өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 4-т “Ажлын цагийг бүртгэхдээ хүн нэг бүрийн өглөө, өдөр ажилдаа ирсэн цагийг 1, 3 мөрөнд, өдөр, орой тарсныг 2, 4 дүгээр мөрөнд, тухайн өдрийн нийт ажилласан цагийг 5 дугаар мөрөнд, илүү ажилласан цагийг ажилласан цагт оруулахгүйгээр зохих шифрээр ажилласан цагийн ард 5 дугаар мөрөнд тус тус бүртгэнэ” гэж заасныг зөрчсөн, хэрэгжүүлж ажиллаагүй байна.
   ***Шийдвэрлэсэн нь:*** Цаашид ажлын цаг ашиглалтын бүртгэлийг сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралтын 4 дэх заалтыг дагуу хөтөлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Б/33 тушаал /илүү цаг 26 ажилтан тус дунджаар 35 цаг/, ажлын цаг ашиглалтын бүртгэл хөтлөлт хангалтгүй байна | 1 | 6,100.0 | | | | | | | | | 1 | 6,100.0 |
| | - | - | | | | | | | | | | |
| Дүн | 1 | 6,100.0 | - | - | - | - | - | - | - | - | 1 | 6,100.0 |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 2022 оны Дансны авлагын эцсийн үлдэгдэлд тооцоо нийлсэн акт байхгүй байна | 1 | 3,776.6 | | | 1 | 3,776.6 | | | | | | |
| | - | - | | | | | | | | | | |
| Дүн | 1 | 3,776.6 | - | - | 1 | 3,776.6 | - | - | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант онд 3 байгууллагаас 14,328.6 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ийн төлбөрийн баримт гаргуулан аваагүй байна | 1 | 14,328.6 | | | 1 | 14,328.6 | | |
| | | - | | | | - | | |
| Дүн | 1 | 14,328.6 | 0 | - | 1 | 14,328.6 | 0 | - |
| Нийт дүн | 1 | 14,328.6 | 0 | - | 1 | 14,328.6 | 0 | - |